



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн аудитын тайлан



Орон нутгийн 2023 оны татварын орлогыг 1,713.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн ч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

АГУУЛГА



	Агуулга	3-4
Тайлан бэлтгэсэн:	Товчилсон үг	4
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Дарга, тэргүүлэх аудитор	Ерөнхий мэдээлэл	6
М.Батсуурь	Бүлэг 1. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2023 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.	7
Аудитын менежер	1.1. Увс аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.	7-9
М.Бат-Амгалан	1.2. Увс аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн зарлагыг өмнөх оны суурь үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.	
Ахлах аудитор	Бүлэг 2. Орон нутгийн татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 1,713.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.	9-11
Ч.Мөнхтогтох	2.1. Орон нутгийн 2023 оны татварын орлогын төлөвлөгөөг 110.1 хувиар биелүүлсэн байна.	12
Аудитор	2.2. Орлогын бүх гүйлгээ тухайн Төсөв захирагчийн төрийн сангийн дансаар дамжин хийгдсэн байна.	12-14
Т.Золоо	Бүлэг 3. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,158.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.	14
2024 оны 04 дүгээр сар	3.1 Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,158.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.	15
	3.2. Сангийн яамны хянасан бүтэц, орон тооны суурь тоо гүйцэтгэлээр зөрүүтэй байна.	15-17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 4. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 3,024.5 сая төгрөгийн ашигтай гарсан байна.	18
	4.1 Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 3,024.5 сая төгрөгийн ашигтай гарсан байна.	19
	4.2. Орон нутгаас баталсан Халамжийн сангийн төсвийг 24.1 сая төгрөгийн хэмнэсэн байна.	19
	4.3. Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн орлого төлөвлөснөөс 2,019.3 сая төгрөгөөр давж биелсэн байна.	20
Хаяг:	4.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн орлого төлөвлөснөөс 251.4 сая төгрөгөөр илүү төвлөрсөн байна.	21
Увс аймаг дахь Төрийн аудитын газар,	4.5. Орон нутгийн төсөвт 5,920.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.	21-22
Улаангом сум, 3 дугаар баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	4.6. Төрийн хэмнэлтийн тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байгаа ч хуулийн зарим зүйл заалттай холбоотой зөрчил байна.	23
	4.7. Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 16/01 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.	23-26
		26
		26-29

	86.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.	
		30
	Дүгнэлт	31
	Зөвлөмж	

Товчилсон үгийн тайлал:

1	УИХ	Улсын Их Хурал
2	ҮАГ	Үндэсний аудитын газар
3	ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
4	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
5	БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт
6	ЭМ	Эрүүл мэнд
7	ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
8	НХХ	Нийгмийн хамгаалал хөдөлмөр
9	СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
10	ОН	Орон нутгийн
11	ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
12	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
13	ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогын гүйцэтгэл
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын гүйцэтгэл
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, Халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын санг хамруулан судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

4. Аудитын арга зүй:

Аудитыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 100, 200, 2000-2899, Монгол улсын Төрийн аудитын MNS 6817-4:2020, Санхүүгийн аудитын тулгуур зарчим, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”-ийн дагуу аудитын зорилго, зорилтын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт боловсруулав.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлага, зөвлөмжид дурдагдсан зөрчлийг аудитын тайланд давхардуулан тусгаагүй болно.

5. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг

хангуулж, чанарын хяналтыг хэрэгжүүлэн, багийг ахлах аудитор Ч.Мөнхтогтох ахалж, аудитор Т.Золоо нар төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- ❖ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль
- ❖ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- ❖ Татварын багц хууль
- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

7. Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалтад “Төсвийн жилийн хязгаарт багтаасан байх” гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулсан байна.

Аймаг, сумдын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтад “Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу орон нутгийн 2023 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 57,823.7 сая төгрөгөөр, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 57,823.7 сая төгрөгөөр баталжээ. 2023 онд нийт 52,931.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,891.8 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасны дагуу гаргаж, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 7/569 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

Бүлэг: 1 Увс аймгийн нэгдсэн төсвийн 2023 оны орлого,
зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан
төлөвлөсөн байна.

**1.1. Увс аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны
гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.**

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн хүрээнд Сангийн яамнаас төсвийн нийт орлого ба улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 46,028.2 сая төгрөгөөр хянасан байна.

Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/8031 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулж Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэл удирдамж, өмнөх оны орлогын гүйцэтгэлийг тус тус үндэслэн орон нутгийн төсвийн орлогыг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 415.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 46,443.3 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу 2023 оны орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 57,823.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт:1 / сая.төг/

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2023 он	
		Анх батлагдсан	Тодотгол
Б	1	2	3
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2023 оны төсвийн тухай хууль 2022.11.11	Аймгийн ИТХ-ын 2022.12.02 -ны 11/03 тогтоол	Аймгийн ИТХ-ын 2023.07.21 -ны 14/01 тогтоол
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	13,774.0	19,932.5	21,105.8
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	40,408.9	46,443.3	52,931.9
УРСГАЛ ОРЛОГО	13,774.0	19,205.6	20,378.9
Татварын орлого	12,170.0	15,713.5	16,936.6
Татварын бус орлого	1,604.0	3,492.1	3,442.3
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	-	726.9	726.9
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	26,634.9	26,510.8	31,826.1
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	7,103.9	9,096.3	11,324.0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	14,755.3	17,414.5	20,498.1
Бусад тусламж			4.0
Урьд оны үлдэгдлээс		3,577.7	4,891.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос		0.0	0.0

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Урсгал орлогын талаар: Орон нутгийн 2023 оны орон нутгийн төсөвт татварын орлого 16,936.6 сая, татварын бус орлого 3,442.3 сая, нийт 20,378.9 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн талаар: Орон нутгийн төсөвт 2023 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 11,324.0 сая, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 20,498.1 сая, бусад тусламж 4.0 сая, нийт 31,826.1 сая төгрөгийн татаас санхүүжилт авахаар төлөвлөжээ.

Хөрөнгийн орлого: Орон нутгийн 2023 оны хөрөнгийн орлогоос 726.9 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 52,931.9 сая төгрөгөөр тодотгон баталсныг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь харуулбал:


Хүснэгт:2 /сая.төг/

№	Үзүүлэлт	2023 оны батлагдсан төсөв
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	52,931.9
	НИЙТ ОРЛОГО	21,105.8
A	УРСГАЛ ОРЛОГО	20,378.9
1	Татварын орлого	16,936.6
1.1	Орлогын албан татвар	11,336.2
1.1.1	Хувь хүний орлогын албан татвар	12,248.7
1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(912.5)
1.2	Өмчийн татвар	1,644.5
1.3	Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	700.0
1.3.1	Тусгай зориулалтын орлого	0.0
1.3.2	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	700.0
1.4	Бусад татвар /төлбөр хураамж/	3,255.9
2	Татварын бус орлого	3,442.3
Б	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	726.9
Б-1	Хөрөнгө борлуулсны орлого	726.9
В	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	31,826.1
В-1	ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	11,324.0
В-2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	20,498.1
В-3	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0.0
В-4	ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	0.0
В-5	ЭМД санхүүжих	0.0
В-6	Бусад тусламж	4.0

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Орон нутгийн төсвийн суурь орлогын 80.3 хувийг татварын орлогоос, 16.3 хувийг татварын бус орлогоос, 3.4 хувийг хөрөнгийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

График 1



Татварын орлогын 63.7 хувийг Хувь хүний орлогын албан татвараас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

График 2



1.2. Увс аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн зарлагыг өмнөх оны суурь үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолуудаар орон нутгийн 2023 оны төсвийн нийт зарлагыг 49,869.3 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолуудаар 57,823.7 сая төгрөг болгон тодотгон баталсан байна.

Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/8031 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулж ИТХ-аар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэл”, Сангийн яамнаас хянасан суурь төсвийн зарлагыг үндэслэн төсвийн зарлагыг анх төлөвлөсөн байна.

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд УИХ-аас тодотгол хийсний дагуу орон нутгийн төсөвт тодотгол хийсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:
Хүснэгт:3 /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он	
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв
Б	1	2	3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,162.4	49,869.3	57,823.7
УРСГАЛ ЗАРДАЛ	29,740.1	33,184.1	38,478.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,121.8	31,735.1	36,973.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,552.1	10,843.1	14,440.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,297.8	1,402.2	1,813.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,226.7	11,160.4	10,894.6
Хангамж, бараа материалын зардал	1,082.4	1,206.7	1,376.3
Нормативт зардал	190.4	267.4	266.4
Эд хогшил, урсгал засварын зардал	957.9	771.3	1,107.2
Томилолт, зочны зардал	278.3	356.7	531.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,222.9	2,002.7	2,099.1
Бараа үйлчилгээний бусад зардал	3,313.2	3,724.6	4,444.4
ТАТААС	28.0	28.0	28.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	28.0	28.0	28.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,590.3	1,421.0	1,477.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	435.4	0.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	1,154.9	1,421.0	1,477.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,602.5	13,759.7	16,399.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,819.9	2,925.5	2,945.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,619.6	49,869.3	57,823.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,103.9	9,096.3	11,324.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.0		
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	7,103.9	9,096.3	11,324.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,207.9	36,951.3	42,489.2
Орон нутгийн төсвөөс	33,207.9	36,951.3	42,489.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,307.8	3,821.8	4,006.5
БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	4.0

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал өмнөх оноос 3,888.4 сая төгрөгөөр өссөн нь "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол гарсантай холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өмнөх оноос өссөн нь шинээр баригдсан барилга байгууламж нэмэгдсэн, дулааны үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой байр ашиглалтын тогтмол зардалд 1,667.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт нэмж тусгаснаас шалтгаалжээ.

Бараа, ажил үйлчилгээний зардлын 39.1 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, 4.9 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 29.5 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 3.8 хувийг хангамж, бараа

материалын зардал, 0.7 хувийг норматив зардал, 3.0 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 1.4 хувийг томилолт, зочны зардал, 5.7 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 12 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

График 3

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ



Нийт зардал, цэвэр зээлийн дүнгийн 67 хувь нь урсгал зардал, 28 хувь нь хөрөнгийн зардал, 5 хувь нь эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл байхаар төлөвлөсөн байна.

БҮЛЭГ:2

Орон нутгийн татварын орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 1,713.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.1. Орон нутгийн 2023 оны татварын орлогын төлөвлөгөөг 110.1 хувиар биелүүлсэн байна.

Увс аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 52,931.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 53,689.3 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт:4 /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он		Гүйцэтгэл	Зөрүү
		Анх батлагдсан	Тодотгосон төсөө		
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	42,814.8	46,443.3	52,931.9	53,689.3	757.4
НИЙТ ОРЛОГО	20,955.6	19,932.5	21,105.8	22,110.7	1,005.0
УРСГАЛ ОРЛОГО	20,632.3	19,205.6	20,378.9	21,909.8	1,531.0
Татварын орлого	17,043.7	15,713.5	16,936.6	18,650.5	1,713.9
Орлогын албан татвар	12,169.7	10,181.5	11,336.2	13,549.4	2,213.2
Хувь хүний орлогын албан татвар	12,873.2	10,881.5	12,248.7	14,461.9	2,213.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(703.4)	(700.0)	- 912.5	- 912.5	-
Өмчийн татвар	1,360.3	1,562.7	1,644.5	1,521.1	(123.4)
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	410.2	700.0	700.0	715.3	15.3
Тусгай зориулалтын орлого		-	-	-	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	410.2	700.0	700.0	715.3	15.3
Бусад татвар /төлбөр хураамж/	3,103.4	3,269.2	3,255.9	2,864.7	(391.3)
Татварын бус орлого	3,588.6	3,492.1	3,442.3	3,259.3	(182.9)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	323.3	726.9	726.9	200.9	(526.0)
Хөрөнгө борлуулсны орлого	323.3	726.9	726.9	200.9	(526.0)
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	21,859.1	26,510.8	31,826.1	31,578.5	(247.6)
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	7,103.9	9,096.3	11,324.0	11,080.4	(243.6)
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	14,755.2	17,414.5	20,498.1	20,498.1	(0.0)
Бусад орлого			4.0		(4.0)

Эх сурвалж: /ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Улсын төсвөөс олгох санхүүжилтийн орлогыг 31,826.1 сая төгрөгөөр баталж, 31,578.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлэх санхүүжилтийн орлогыг 247.6 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн суурь орлогыг татварын орлогоос 16,936.6 сая, татварын бус орлогоос 3,442.3 сая, хөрөнгийн орлогоос 726.9 сая, нийт 21,105.8 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр татварын орлого 18,650.5 сая, татварын бус орлого 3,259.3 сая, хөрөнгийн орлого 200.9 сая, нийт 22,110.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 104.7 хувиар биелүүлсэн байна.


Орон нутгийн төсвийн татварын орлогыг 16,936.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 18,650.5 сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөг 1,713.9 сая төгрөгөөр буюу 110.1 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн татварын орлого төлөвлөснөөс давж биелэхэд Засгийн газрын 2023 оны 241 дүгээр "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ.

Татварын бус орлого төлөвлөснөөс 182.9 сая төгрөгөөр тасарсан нь Сагил, Завхан сум төсөвт байгууллагын өөрийн орлогыг дутуу бүрдүүлснээс шалтгаалжээ.

Хөрөнгө борлуулсны орлого 526.0 сая төгрөгөөр тасарсан нь 2023 онд "Чандмань-Увс" ХХК-ийн хөрөнгийг худалдан борлуулахаар төлөвлөсөн ч хэрэгжээгүйгээс шалтгаалжээ.

Татварын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна:

График 4



Өмчийн татварын орлого 123.4 сая, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 391.3 сая төгрөгөөр тасарч, хувь хүний орлогын албан татвар 2,213.2 сая, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар 15.3 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/07 дугаар тушаалаар "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам"-ыг баталсан байна.

Увс аймагт 2023 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас нийт 1,634.0 сая төгрөг орохоор төлөвлөсөн байна. Үүнээс улсын төсөвт 1,039.0 сая, аймгийн төсөвт 595.0 сая төгрөг орохоор тооцжээ.

Гүйцэтгэлээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас нийт 1,680.1 сая төгрөгийн орлого оржээ. Уг орлогыг Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан журмын 6.1-д “Татварын орлогын хуваарилалтын үйл ажиллагааны нэгдсэн хяналтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ”, 6.3-д “Аймаг, нийслэлийн төсвийн орлогын гүйцэтгэлийн бүртгэл, өөрчлөлт, баталгаажуулалтын нэгдсэн хяналтыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, төсөв бүрийн хяналтыг харьяалах татварын алба хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Сангийн яам, Татварын Ерөнхий газраас тооцооллыг хийж 980.1 сая төгрөгийг улсын төсөвт, 700.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт хуваарилсан байна.

2.2. Орлогын бүх гүйлгээ тухайн төсөв захирагчийн төрийн сангийн дансаар дамжин хийгдсэн байна.

Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу Төсвийн байгууллагуудын болон төсөл хөтөлбөр, сангийн орлого, зарлагын гүйлгээ нь Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжин хийгдсэн байна.

Сангийн сайдын 2011 оны 131/25/1289 тоот гэрээний дагуу арилжааны банкнуудад татварын нэр төрлөөр нь “тэг” үлдэгдэлтэй дансанд оруулсан татварын орлогыг сар бүрийн сүүлийн өдөр төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн татварын газраас ирүүлсэн улс, орон нутгийн төсвийн 2023 оны татварын ногдуулалт, үлдэгдлийн судалгааны дүн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн орлогын тайлангийн дүнгээс 486.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөө 2022 онд тасарсан тул 373.9 сая төгрөгийг 2023 оны аж ахуйн нэгжийн албан татварын орлогоос урьдчилж авсан байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын орлогыг тайлант оны сүүлийн өдрөөр тасалбар болгон тусгасан байхад Татварын газар нь дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр төвлөрүүлсэн орлогыг өмнөх оны орлогоор хүлээн зөвшөөрч байна.
- Газар, ан агнуурын дуудлага худалдааны орлогыг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын бус орлогоор тусгасан байна.

Дээрх асуудлыг нэгдсэн тайланд тусгуулахаар Үндэсний аудитын газар санал хүргүүлэхээр болов.

БҮЛЭГ:3. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,158.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

3.1 Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,158.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Увс аймгийн Орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн зарлагыг 57,823.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 50,664.8 сая төгрөгийг зарцуулж 7,158.9 сая төгрөгийг хэмнэсэн байна. Тайлант оны нийт зарлагын гүйцэтгэл нь өмнөх оноос 8,502.4 сая төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны хөтөлбөрөөр бэлтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан дараах байдалтай байна.

Хүснэгт 5 /сая.төг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-3
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,162.4	49,869.3	57,823.7	50,664.8	(7,158.9)
2	УРСГАЛ ЗАРДАЛ	29,740.1	33,184.1	38,479.0	36,321.5	(2,157.5)
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,121.8	31,735.1	36,973.5	34,889.2	(2,084.4)
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,552.1	10,843.1	14,440.5	13,904.1	(536.5)
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,297.8	1,402.2	1,813.1	1,719.9	(93.3)
6	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,226.7	11,160.4	10,894.6	10,304.5	(590.0)
7	Хангамж, бараа материалын зардал	1,082.4	1,206.7	1,376.3	1,319.0	(57.3)
8	Нормативт зардал	190.4	267.4	266.4	266.2	(0.2)
9	Эд хогшил, урсгал засварын зардал	958.0	771.3	1,107.2	1,074.6	(32.6)
10	Томилолт, зочны зардал	278.3	356.7	531.9	479.1	(52.8)
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,222.9	2,002.7	2,099.1	1,731.6	(367.5)
12	Бараа үйлчилгээний бусад зардал	3,313.2	3,724.6	4,444.4	4,090.2	(354.2)
13	ХҮҮ	-	-	-	-	0.0
14	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-	0.0
15	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-	0.0
16	ТАТААС	28.0	28.0	28.0	26.7	(1.3)
17	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-	0.0
18	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	28.0	28.0	28.0	26.7	(1.3)
19	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,590.3	1,421.0	1,477.5	1,405.6	(71.8)
20	Засгийн газрын урсгал шилжүүлэг	435.4	-	-	-	0.0
21	Бусад урсгал шилжүүлэг	1,154.9	1,421.0	1,477.5	1,405.6	(71.8)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,602.5	13,759.7	16,399.2	12,641.9	(3,757.4)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,819.9	2,925.5	2,945.5	1,701.4	(1,244.1)

Эх сурвалж: /ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

Цалин хөлс ба нэмэгдэл урамшууллын зардал 536.4 сая төгрөг буюу 3.7 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 93.3 сая төгрөг буюу 5.1 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 590.0 сая төгрөг буюу 5.4 хувиар, хангамж бараа материалын зардал 57.3 сая төгрөг буюу 4.2 хувиар, норматив зардал 0.2 сая төгрөг буюу 0.07 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 32.6 сая төгрөг буюу 2.9 хувиар, томилолт зочны зардал 52.8 сая төгрөг буюу 9.9 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 367.5 сая төгрөг буюу 17.5 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 354.2 сая төгрөг буюу 7.9 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

Увс аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн баталжээ.

Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 195 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, арга хэмжээний зорилтот түвшинд бүрэн хүрсэн 100 хувьтай арга хэмжээ 135, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа 90.0 хувьтай арга хэмжээ 10, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 70.0 хувьтай арга хэмжээ 23, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн 50.0 хувьтай арга хэмжээ 11, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 30 хувьтай арга хэмжээ 7, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй тэг хувьтай арга хэмжээ 7, нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж нь 86.8 хувьтай үнэлэгджээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн зарцуулалт дараах байдалтай байна.

Хүснэгт 6 /сая.төг/

№	Хөтөлбөрийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа/70105/	3,544.9	3,318.2	93.61
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/70708/	36,252.1	31,604.4	87.18
3	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх/70426/	288.4	286.4	99.3
4	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага/70429/	270.4	264.4	99.3
5	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого/	-	-	-
6	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх/70708/	635.0	613.0	96.5
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх/70709/	123.9	116.6	94.1
8	Мал аж ахуйг хөгжүүлэх/70801/	639.0	639.0	100
9	Авто зам/711101/	745.6	420.5	56.4
10	Ойжуулалт/71403/	269.4	241.1	89.5
11	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/71411/	1,283.3	1,281.6	99.8
12	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх/71413/	555.9	451.0	81.1

13	Эмнэлгийн тусламж үйлчилгээ/71602/	799.8	739.3	92.4
14	Биеийн тамир спорт/71702/	348.9	348.9	100
15	Соёл урлаг/71702/	1,137.0	918.4	80.8
16	Сургуулийн өмнөх боловсрол/71801/	1,670.4	1,544.4	92.5
17	Ерөнхий боловсрол/71802/	5,606.1	5,507.6	98.2
18	Мэргэжлийн боловсрол/71804/	400.1	399.9	99.9
19	Нийгмийн халамж/71902/	831.8	807.7	97.1
20	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих/72101/	2,296.2	1,038.1	45.2
21	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал/72206/	34.6	34.6	100.0
22	Ахмад настны хөгжил хамгаалал/72208/	58.9	57.8	98.2
23	Гэр бүлийн хөгжил, хамгаалал/72212/	32.0	32.0	100
Нийт дүн		57,823.7	50,664.8	87.6

Эх сурвалж: ЗДТГ-ын ХШҮХ-ийн үнэлгээ/

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 57,823.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 50,664.8 сая төгрөг зарцуулсанд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 2,296.2 сая төгрөгийн зээл олгохоор төсөвлөсөн ч Хоршоо хөгжүүлэх сангийн журмын шаардлагад нийцсэн хоршоо цөөн тул зээл олголт төлөвлөсөн хэмжээнээс 1,258.1 сая төгрөгөөр дутуу хэрэгжсэн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсөвт байгууллагууд тодорхой хэмжээнд хэмнэлт гарган ажилласан, ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлсэн.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт 7 /сая.төг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-3
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,619.6	49,869.3	57,823.7	52,837.6	(4,986.0)
2	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,103.9	9,096.2	11,324.0	11,080.4	(243.5)
3	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	7,103.9	9,096.2	11,324.0	11,080.4	(243.5)
4	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,207.9	36,951.2	42,489.2	40,024.8	(2,464.3)
5	Орон нутгийн төсвөөс	33,207.9	36,951.2	42,489.2	40,024.8	(2,464.3)
6	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-		-
7	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,307.8	3,821.8	4,006.4	1,732.2	(2,274.2)
8	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС АНХҮҮЖИХ		-	4.00		(4.00)

Зардлыг санхүүжүүлэх 52,837.6 сая төгрөгийн эх үүсвэрийг гүйцэтгэлээр авч үзвэл улсын төсвөөс 11,080.4 сая төгрөг буюу 20.9 хувийг, орон нутгийн төсвөөс

40,024.9 сая төгрөг буюу 75.7 хувийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,732.3 сая төгрөг буюу 3.3 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

3.2. Сангийн яамны хянасан бүтэц, орон тооны суурь тоо гүйцэтгэлээр зөрүүтэй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгддэг 46 төсвийн байгууллагаас 1 байгууллагын орон тоо Сангийн яамны хянасан суурь тооноос зөрүүтэй байна.

Үүнд:

- ❖ Санхүү, төрийн сангийн хэлтсээс Улаангом сумын Засаг даргын тамгын газрын орон тоог 68 байхаар төлөвлөн хүргүүлж Сангийн яамаар хянуулсан байна. Увс аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/01 дүгээр захирамжаар Улаангом сумын Засаг даргын тамгын газрын орон тоог 70 гэж баталж, гүйцэтгэлээр 69 орон тоотой ажилласан байна.

Дээрх зөрчилд Сангийн яамны хянасан суурь орон тоонд багтаан харьяа байгууллагын бүтэц орон тоог батлах зөвлөмж өглөө.

Завхан сумын Засаг даргын тамгын газар гүйцэтгэлээр 25 орон тоотой ажилласан ч төсвийн гүйцэтгэлийн тайланд орон тооны гүйцэтгэлийг 26 гэж тайлагнасан байна. Цаашид орон тоог бодит гүйцэтгэлээр нь тайлагнаж байхыг зөвлөлөө.

Төлөвлөсөн орон тооноос дараах 5 байгууллага орон тоо дутуу ажилласан байна. Үүнд:

Хүснэгт 8 /сая.төг/

№	Байгууллагын нэр	Удирдах		Гүйцэтгэх		Үйлчлэх		Гэрээт		Нийт	
		төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
1	Малчин сумын Засаг даргын тамгын газар	7	7	9	11	3	4	12	3	31	25
2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	1	7	6	2	2	0	0	10	9
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	1	43	41	7	7	1	1	52	50
4	Тариалан сумын Засаг даргын тамгын газар	9	9	10	9	3	3	8	8	30	29
5	Түргэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	1	3	2	0	0	0	0	4	3
Дүн		19	19	72	69	15	16	21	12	127	116

Хүснэгтээс харахад 2023 онд Малчин сумын Засаг даргын тамгын газар 6, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 1, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2, Түргэн сумын Засаг даргын тамгын газар 1, Түргэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 1 орон тоогоор тус тус дутуу ажилласан байна.

Малчин сумын Засаг даргын тамгын газар орон тоогоо батлуулахдаа гэрээт ажилтны 4 орон тоог нэмж төлөвлөн 31 орон тоогоор Сангийн яаманд хянуулсан байна. Цаашид орон тооны хязгаарыг хянаж хүргүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөв.

БҮЛЭГ:4. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 3,024.5 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

4.1. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 3,024.5 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

Увс аймгийн 2022 оны төсвийн урсгал тэнцлийг 18,100.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал тэнцэл 14,411.7 сая төгрөг байна.

Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэл

Хүснэгт 9 /сая. төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3	4	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	42,814.8	46,443.3	52,931.9	53,689.3	757.38
А.УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	20,632.2	19,205.6	20,378.9	21,909.8	1,530.96
1.Татварын орлого	17,043.7	15,713.5	16,936.6	18,650.5	1,713.89
2.Татварын бус орлого	3,588.5	3,492.1	3,442.3	3,259.3	(182.9)
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	323.3	726.9	726.9	200.9	(526.0)
В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	21,859.2	26,510.8	31,826.1	31,578.5	(247.6)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,162.4	49,869.3	57,823.7	50,664.8	(7,158.9)
А.УРСГАЛ ЗАРЛАГА	29,740.0	33,184.1	38,479.0	36,321.5	(2,157.5)
1.Бараа, үйлчилгээний зардал	28,121.8	31,735.1	36,973.5	34,889.2	(2,084.4)
1.1. Цалин, хөлс	10,552.0	10,843.1	14,440.5	13,904.1	(536.5)
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	1,297.8	1,402.2	1,813.1	1,719.9	(93.3)
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	16,271.8	19,489.8	20,719.9	19,265.2	(1,454.7)
3.Татаас ба урсгал шилжүүлэг	1,618.3	1,449.0	1,505.5	1,432.3	(73.1)
3.1. Татаас	28.0	28.0	28.0	26.7	(1.3)
3.2. Урсгал шилжүүлэг	1,590.3	1,421.0	1,477.5	1,405.6	(71.8)
Б.ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,602.5	13,759.7	16,399.2	12,641.9	(3,757.4)
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	1,819.9	2,925.5	2,945.5	1,701.4	(1,244.1)
1.Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	1,819.8	2,925.5	2,945.5	1,701.4	(1,244.1)
УРСГАЛ ТЭНЦЭЛ	(9,107.8)	(13,978.6)	(18,100.1)	(14,411.7)	3,688.4
НИЙТ ТЭНЦЭЛ	652.4	(3,426.0)	(4,891.8)	3,024.5	7,916.31
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР		0.0	0.0	0.0	-
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	652.4	0.0	0.0	3,024.5	-
2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих		3,577.7	4,891.8	0.0	-
3. Бусад /ТБӨО/		1,813.9	1,915.8	0.0	-

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа/

4.2. Орон нутгаас баталсан Халамжийн сангийн төсвийг 24.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Орон нутгийн төсвөөс Халамжийн санд 831.7 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 807.7 сая төгрөгийг 2 нэр төрлийн халамжийн үйлчилгээнд зарцуулж 24.1 сая төгрөг хэмнэснийг буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн Халамжийн сангийн зарлагыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10 /сая. төг/

№	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Олон нийтийн оролцоон түшиглэсэн халамжийн үйлчилгээ	765.7	764.5	1.3
2	Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	66.0	43.2	22.8
	Нийт дүн	831.7	807.7	24.1

Эх сурвалж: /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын судалгаа/

Халамжийн сангийн төсөв хэмнэгдэхэд амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийн хэмнэлт шууд нөлөөлсөн байна. Амьжиргааг дэмжих онцгой тохиолдлын нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 55 иргэнд олгохоос нийт 36 иргэний материал ирүүлснээс шаардлага хангасан 35 иргэнд олгосон байна.

4.3. Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн орлого төлөвлөснөөс 2,019.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого:

Нийгмийн даатгалын санд 45,552.3 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 43,532.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 2,019.3 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар тасарсан байна.

Хүснэгт 11 /сая.төг/

№	Нийгмийн даатгалын сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	39,996.5	38,207.7	1,788.8
2	Тэтгэмжийн даатгал	3,072.9	2,889.0	183.9
3	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	1,887.1	1,887.0	0.1
4	Ажилгүйдлийн даатгал	595.7	549.2	46.5
	Нийт дүн	45,552.3	43,532.9	2,019.3

Эх сурвалж: Нийгмийн даатгалын газрын судалгаа

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2,019.3 сая төгрөгөөр тасрахад тэтгэврийн даатгалын сангийн орлого 1,788.8 сая төгрөгөөр тасарсан нь гол нөлөөг үзүүлсэн байна. Тэтгэврийн даатгалын сангийн орлого тасрахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг төрийн албан хаагчдын цалингийн есөлттэй холбоотой тодотгол хийгдэж 16,100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 45,552.3 сая төгрөгөөр баталсан байна. Нийгмийн даатгалд хамрагдах ажил олгогч, даатгуулагчийн тоог өнгөрсөн оны гүйцэтгэлээс өсөхөөр төлөвлөсөн ч тайлант онд нийгмийн даатгалд

хамрагдсан ажил олгогчийн тоо өнгөрсөн оны гүйцэтгэлээс 15 ажил олгогчоор буюу 1.4 хувиар буурсан, сайн дурын даатгуулагчийн тоо 1127 даатгуулагчаар буюу 17.6 хувиар буурсан байна.

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээр ажил олгогч болон сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага:

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн нэр төрөл бүрээр нийт 99,192.5 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 95,952.9 сая төгрөг зарцуулж төлөвлөснөөс 3,239.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хүснэгт 12 /сая. төг/

№	Нийгмийн даатгалын сангийн зарлагын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	93,580.6	90,584.6	2,996.0
2	Тэтгэмжийн даатгал	4,410.8	3,996.7	414.1
3	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	564.5	508.0	56.5
4	Ажилгүйдлийн даатгал	636.6	863.6	-227.0
Нийт дүн		99,192.5	95,952.9	3,239.6

Эх сурвалж: Нийгмийн даатгалын газрын судалгаа

Нийгмийн даатгалын зарлага төлөвлөснөөс 3,239.6 сая төгрөгөөр хэмнэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 2,996.0 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангийн хэмнэлт нь тэтгэврийн төрөл тус бүрээрээ хэмнэгдсэнтэй холбоотой. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон иргэний тоог 2023 онд нэмэгдэхээр төлөвлөсөн боловч өмнөх онтой харьцуулахад 137 иргэн, тэжээгчээ алдсаны тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тоо 17 иргэнээр буурсан нь нөлөөлсөн байна.
- Тэтгэмжийн даатгалын сангийн зардал 414.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авагчдын тоо өнгөрсөн оноос 441 даатгуулагчаар буурснаар олгосон тэтгэмж 136.0 сая, оршуулгын тэтгэмж 132.4 сая, сайн дурын даатгалд хамрагдсан эхчүүдийн тоо өмнөх оноос 307 даатгуулагчаар буурснаар 145.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой.
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зардал 56.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь үйлдвэрлэлийн ослын хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмж 20.2 сая, рашаан сувиллын зардал 17.6 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой.
- Ажилгүйдлийн тэтгэмж төлөвлөснөөс 227.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

4.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн орлого төлөвлөснөөс 251.4 сая төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого: Эрүүл мэндийн даатгалын санд 6,437.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 6,689.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөө 251.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

Хүснэгт 13 /сая. төг/

№	Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого	5,675.2	5,994.8	319.6
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагчдын шимтгэлийн орлого	762.7	690.3	-72.3
3	Бусад орлого	0.0	4.1	4.1
Нийт		6,437.8	6,689.2	251.4

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн судалгаа

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 251.4 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар давж биелсэн байна. Энэ нь ажил олгогч байгууллагын даатгуулагчийн тоо өмнөх оноос 249 даатгуулагчаар өссөнтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал: Эрүүл мэндийн даатгалын сангаас 2023 оны гүйцэтгэлээр 33,256.0 сая төгрөг зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг өмнөх онтой харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 14 /сая.төг/

№	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төрөл	2022 он Гүйцэтгэл	2023 он Гүйцэтгэл
1	Төрийн өмчийн эмнэлэг	13,032.3	14,787.3
2	Хувийн хэвшлийн эмнэлэг	1,345.0	1,226.0
3	Эмийн сан /энгийн эм/	1,878.2	2,181.2
4	В, вирусийн эм	66.5	0.0
	Урьдчилан сэргийлэх үзлэг	34.7	0.0
5	Эрт илрүүлэг /ЭМЯ/	209.2	737.4
6	В С вирусийн илрүүлэг баталгаажуулах, шинжилгээ	0.0	0.0
7	Эрүүл шүд-Эрүүл хүүхэд	0.0	0.0
8	Өрх, сумын ЭМТ	591.3	1,026.4
9	Ковидын тусламж хэвтэн эмчлүүлэх	1,424.9	0.0
10	Ковидын гэрийн тусгаарлалт	578.08	0.0
11	Ковидын вакцинжуулалт	31.3	0.0
12	Ковидын шинжилгээ /Тандалт/	0.0	0.0
13	Ковидын шинжилгээ /Сорьц/	0.0	0.0
14	Төлбөрийн төр хариуцах эмийн санхүүжилт	0.0	20.6
15	Тандалт -5000	6.6	0.0
16	Сорьц-50000	66.0	0.0
17	ӨЭМТ-н анхан шатны санхүүжилт /Нэг иргэн/	1,485.6	1,793.9
18	СЭМТ-н анхан шатны санхүүжилт /Нэг иргэн/	6,587.7	8,472.1
19	СЭМТ-н Үндсэн тусламж үйлчилгээ /Хэвтэн, яаралтай, түргэн/	3,779.9	3,011.1
НИЙТ		31,130.8	33,256.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн судалгаа

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт өмнөх оноос 2,125.2 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг 2021 оноос гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.

4.5. Орон нутгийн төсөвт байгууллагуудад 5,920.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд хандив, тусламж 65.7 сая, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-өөс 332.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 771.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,750.6 сая, нийт 5,920.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнээс: урсгал зардалд 5,371.5 сая, хөрөнгийн зардалд 548.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.6. Төрийн хэмнэлтийн тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байгаа ч хуулийн зарим зүйл заалттай холбоотой зөрчил байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36 дахь заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна”, 40.4 дэх хэсэгт “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна”, 40.4.1 дэх заалтад “төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах”, 65 дугаар зүйлийн 65.1.3 дахь хэсэгт “холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай төрийн чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төлөөлөн гүйцэтгэх гэрээг байгуулж ажиллах” гэж заажээ.

Мөн Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 60.1.1 дэх заалтад “Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах”, 60.1.7 дахь заалтад “Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах”, 60.1.17 дахь заалтад “Сумдын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих” гэж заасан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас харьяа төсвийн захирагч нарт анхаарч ажиллах талаар дараах чиглэл хүргүүлжээ. Үүнд:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн зүгээс харьяа Төсвийн төвлөрүүлэн захирагчдад 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/2200 дугаар “2023 оны батлагдсан төсөв хүргүүлэх тухай”, 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 1/1282 дугаар “2023 оны тодотгон батлагдсан төсөв хүргүүлэх тухай” албан бичгүүдээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах чиглэл өгч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасны дагуу 2024 оны 04 дүгээр 11-ны өдрийн байдлаар Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл нийт 279 байгаагаас 44 тээврийн хэрэгсэл тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэж байна.

Цаашид Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 01/26 дугаар албан бичгийн хэрэгжилтийн хангаж харьяа байгууллагын тээврийн хэрэглийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгох зөвлөмж өглөө.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана" гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл", А/89 дүгээр тушаалаар баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ын дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 40.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: 10.6 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 11.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага, 18.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх заалтад "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15.1.3 дахь заалтад "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай холбоотой нийт 10.6 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

- Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15/06 дугаар тогтоолоор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 20 төлөөлөгчид тус бүр 300.0 мянга, нийт 6,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон,
- Өмнеговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/15 дугаар захирамжаар "Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд" аяны хоолны зардалд 1,335.0 мянган төгрөгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас олгосон,
- Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар захирамжаар "Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд" аяны хоолны зардалд 1,199.2 мянган төгрөгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас олгосон,

- Увс аймгийн Соёл урлагийн газар “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцсон нэр бүхий 4 ажилтанд 1,219.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон,
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга нь аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын шийдвэрүүдийг үндэслэн улирлын үр дүнгийн урамшууллын 650.1 мянган төгрөгийг давхардуулан авсан,
- Өндөрхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2023 оны 02 дугаар сард 313.7 мянган төгрөгийн урамшуулал авсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.2.3 дахь заалтад “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудтай холбоотой 11.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгсөн. Үүнд:

- Завхан сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас дотоод албан томилолт, хэвлэл, хүлээн авалт зэрэг зардлуудад 11,017.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.6 дахь заалтад “Сахилга баттай байх”, 4.2 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.3 дахь заалтад “Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 4.2.7 дахь заалтад “Аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх” гэсэн заалттай холбоотой 18.9 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

- Аймгийн Засаг даргын тамгын газар нь Баруун бүсийн аймгуудын нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультай, ажилтнуудын сургалт, спортын арга хэмжээнд, ирсэн зочид төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,330.0 мянга, Алсын хараа-2050 хөтөлбөрийн хүрээнд Соёлын сэргэлт-2023 арга хэмжээг Увс аймагт зохион байгуулахаар ирсэн урлагийн алдартан, зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,709.0 мянга, Алсын хараа-2050, шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлалд нээлттэй Увс аймаг хөтөлбөр хэрэгжүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн дэмжлэгээс Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар 8,200.0 мянга, нийт 14,239.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авсан,
- Аймгийн Засаг даргын тамгын газар нь Төрийн архивын барилгын нээлтийн арга хэмжээнд зориулан хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахад 160 хүний хүлээн авалтад Засаг даргын нөөц хөрөнгөөс 4,678.0 мянган төгрөг зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэсэн заалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.

- Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг 70 хувиас доош байршуулсан дараах байгууллагуудад ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу албан шаардлага өгсөн. Үүнд:
 - Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч,
 - Өлгий сумын Засаг даргын тамгын газар,
 - Өлгий сумын ИТХ,
 - Ховд сумын Засаг даргын тамгын газар,
- Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг 80 хувиас дээш байршуулсан дараах байгууллагуудад зөвлөмж өглөө.
 - Ховд сумын Соёлын төв
 - Ховд сумын ИТХ

4.7 Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 16/01 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор “Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 6 бодлогын хүрээнд 25 зорилт, 423 арга хэмжээтэйгээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд төрийн албанд чанарын менежментийг нэвтрүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, төрийн ажлын дамжлагыг багасгахад чиглэгдсэн Боршоо боомтын шинэчлэлийн ажлыг эхлүүлж, Ховд-Увс аймгийг холбосон замын ажил Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлыг Польш улсын дэмжлэгээр эхлүүлэхээр болж, мөн дижитал Увс төслийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн жимс жимсгэнийн эх цэцэрлэг, Увс агро төсөл, шинэ сортын тариалалт, жижиг оврын тэжээл боловсруулах цех, сүү цагаан идээ боловсруулах цех, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, загвар хоршоодын хөгжлийг дэмжих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг бодлого тус бүрээр нь товчхон авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн х үндрэлийг даван туулах бодлого

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хүрээнд цар тахлын дараах нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөг арилгах аймгийн бодлогыг 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажилласан байна.

Хоёр. Хүний хөгжлийн бодлого

Боловсролын салбарт 2023 онд сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, сургалтын байгууллага, багшийн гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах, боловсролын

цахим шилжилтийг эрчимжүүлж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилт тавин ажиллаж, ковид цар тахлын улмаас бий болсон хичээл, боловсролын хоцрогдлыг богино хугацаанд нөхөхөд анхаарч ажилласан байна.

2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Наранбулаг сумын 640 хүүхдийн сургууль, Улаангом сумын 8 дугаар цэцэрлэгийн 75 хүүхдийн барилгын өргөтгөлийн ажил, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Улаангом сумын 9 дүгээр цэцэрлэгийн засварыг хийж дуусгасан байна.

Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтын байгууллагын сэтгэл ханамжийн судалгаагаар Увс аймгийн үнэлгээ 2023 онд 95.4 хувь буюу улсын дунджаас 5.2 хувиар дээгүүр байна.

Гурав. Эдийн засгийн бодлого

Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлж, орон нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбох зорилтын хүрээнд эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл арга хэмжээ болох Баруун бүсийн тээвэр логистикийн төв, Гурил тэжээлийн үйлдвэр цогцолборын ТЭЗҮ, зураг төсөл, Улаангом сумын 9, 10, 12-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, гадаргын ус зайлуулах суваг, Давст, Түргэн, Наранбулаг сумын төвийн гэр хорооллын инженерийн дэд бүтэц, Увс нуур-Улаангом чиглэлийн 26.39 км хатуу хучилттай авто зам, Улаангом-Тэс чиглэлийн авто замын зарим хэсгийг сайжруулах ажил, Увс аймаг Улаангом сумын арын 4 замын уулзвараас баруун зам дэлгүүр-Улаан уулын тойрог-Цагаан хаалга хүртэлх баруун тойруугийн авто замын шинэчлэл, Улаантолгойн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг сэргээн засварлах, Туруун голын 109.15 у/м төмөр бетон гүүр, сумын төвийн 1.2 км цемент бетон хучилттай авто зам, Бухын голын 9.6 у/м төмөр бетон гүүр зэрэг ажлуудын зураг төсөл боловсруулан зарим төсөл арга хэмжээг эхлүүлж, зарим төсөл арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлуулсан байна.

Орон нутгийн төсвийн бодлогыг Монгол улсын төсвийн нэгдмэл байдал, төсвийн сахилга батыг хангах, төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн зорилтууд болон хөгжлийн төлөвлөгөөг баримтлан хэрэгжүүлэн ажилласан байна.

Боршоо боомтоор 2023 онд 1.7 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн экспортолж, 17.6 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн импортолсон байна. Сүүлийн жилүүдэд боомтоор орсон болон гарсан хүний тоо өссөн байх бөгөөд 2023 онд 58.0 мянга гаруй иргэд нэвтэрсэн байна.

Дөрөв. Засаглалын бодлого

“Цахим засаглал”, “Цахим аймаг” бодлогыг тодорхойлж, “Цахим үндэстэн” болох зорилтын хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, тоон бичиг үсэгтэн байх “Дижитал Увс” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөөгийн 18 сумын 54 төрийн байгууллагуудын интернэтийн урсгалыг сайжруулах, техник тоног төхөөрөмжөөр хангах, Үндэсний дата төвд бие даасан 3 дата сервер байршуулах, аймгийн нэгдсэн эмнэлэгт сервер, цаг захиалах, шинжилгээний хариу хэвлэж авах киоск төхөөрөмж авах, ухаалаг хаалганы тоног төхөөрөмжийн шинэчлэлт зэрэг ажил хийгдсэн байна.

Увс аймгийн Төрийн архивын барилга нь улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд баригдаж ашиглалтад орсон байна.

Бүс нутгийн эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэгийн ажлын хүрээнд идэвхтэй гадаад хамтын ажиллагааг бий болгох, Монгол улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг хамтран тэмдэглэж аймгийн Засаг даргын албан ёсны айлчлал, уулзалтыг Бүгд найрамдах Киргиз улс, ОХУ-ын Алтайн хязгаар, БНСУ-ын Кёнги, Ульсан, Инчеон хотуудад, ОХУ-ын Тува, Алтайн бүгд найрамдах улсад хийж олон улсын аялал жуулчлалын сүлжээнд холбогдох, эдийн засаг, хөдөө аж ахуй, байгаль орчин, соёл хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулан ажилласан байна.

Тав. Ногоон хөгжлийн бодлого

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд улсын болон орон нутгийн төсвийн 1,278.5 сая төгрөгийн хөрөнгөөр 110 га талбайд ойжуулалт, 50 га талбайд ойн зурвас, 8.3 га талбайд ногоон байгууламж байгуулж, 390 мянга орчим мод, бут сөөг тарьж өмнөх онуудтай харьцуулахад мод тарилтын хэмжээ 5 дахин өссөн байна. Ойн хортон шавжийн судалгааны ажлыг давхардсан тоогоор 231238 га талбайд, ойн арчилгааны огтлолыг 55 га талбайд хийж, 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр Малчин, Өндөрхангай, Наранбулаг, Зүүнхангай сумдын хортонд өртсөн 4000 га талбайд тэмцлийн ажлыг зохион байгуулсан байна.

Амьтны нөөцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх, ашиглалтын нөөцийг бүрдүүлэх зорилгоор аймгийн нарийвчилсан ан агнуурын менежмент төлөвлөгөөг шинэчлэн, 3 сумын 3 агнуурын бүс нутгийг өргөжүүлэн 10 сумын 11 агнуурын бүсийн менежмент төлөвлөгөөг баталснаар 2021-2023 онд агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 15-20 хувиар өсөж, 1.7 тэрбум төгрөг төсөвт төвлөрч, 2023 оны байдлаар 10 сумын 11 агнуурын бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн 5 зүйл амьтны хамгаалал, зохистой ашиглалтын менежментийг 21 нөхөрлөл хариуцан ажиллаж байна.

Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед үүлэнд зориудаар нөлөөлөх арга хэмжээг ОНХС-ийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр нийт 47 удаа зохион байгуулан ажилласан байна.

Зургаа. Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого

Монгол Улсын баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд Увс, Ховд аймгийг холбосон 163.3 км авто замын ажил Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжихээр болсон байна. Энэхүү авто зам нь Алтай Соёны тойрог, цаашлаад Ази-Европыг холбосон авто замын коридор үүсгэж байгаагаараа бүс нутгийн хэмжээнд чухал үүрэгтэй байна. Монгол Улсыг ОХУ-ын Сибирийн тойрог, БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах оронтой авто замаар холбон хил дамнасан тээврийн коридор бий болж, өөрийн орны нутаг дэвсгэрээр олон улсын транзит тээврийг нэвтрүүлэх, Монгол улсын нийгэм, эдийн засаг, дотоодын авто тээврийг эрчимтэй хөгжүүлэх, улмаар хөрш орнуудын дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлж, дотоодын худалдаа, зах зээлийг хөгжих боломж нэмэгдэхээр байна.

Улаангом хотын 3000 м.куб хүчин чадалтай төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, өргөтгөлийн ажлыг Польш улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр болж Монгол талын ерөнхий гүйцэтгэгч “Сан” ХХК ажлыг

эхлүүлэн цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамжийн 4.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 2 дэд өртөөний ажлыг хийж хэрэгжүүлсэн байна. Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 2024 онд эхлэхээр төлөвлөгдсөн байна. Иргэдийн ундны усан хангамж, халуун усны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 386.4 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллажээ.

Дүгнэлт



Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн нэгдсэн төсвийн 2023 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.
2. Орон нутгийн 2023 оны татварын орлогыг төлөвлөснөөс 1,713.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
3. Аймгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,158.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.
4. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 3,024.5 сая төгрөгийн ашигтай гарсан байна.
5. Сангийн яамны хянасан суурь орон тоог гүйцэтгэлээр Улаангом сумын Засаг даргын тамгын газар 1 орон тоогоор хэтрүүлсэн байна.
6. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2023 онд Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 86.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.
7. Төрийн хэмнэлтийн тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байгаа ч хуулийн зарим зүйл заалттай холбоотой зөрчил байна.

Зөвлөмж


Увс аймгийн Засаг дарга Ч.Чимэд танаа:

1. Сангийн яамны хянасан суурь орон тоонд багтаан харьяа байгууллагын бүтэц орон тоог батлах.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 01/26 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТ-АМГАЛАН

Ч.МӨНХТОГТОХ

Т.ЗОЛОО